


Банкуудын зээлийн тайлан

2016 оны 1 дүгээр улирал

Монголбанк “Банкуудын зээлийн тайлан”-г 2016 оны 1 дүгээр улирлаас эхлэн шинэчлэгдсэн маягтын дагуу аван нэгтгэж байна. Шинэчлэгдсэн тайланд Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбар (ЭЗҮАС) тус бүрт олгосон зээлийн зээлдэгчдийн тоо, тайлант сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа болон хүү, тухайн салбарын зээлд харгалзах зээлийн эрсдэлийн сангийн мэдээллийг нэмж тусгаснаас гадна тайлангийн давтамж улирлаар байсныг сараар болгов.

Нийт зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 1.1 хувиар буюу 130.9 тэрбум төгрөгөөр өссөн бол өмнөх оны мөн үеэс 3.6 хувь буюу 446.4 тэрбум төгрөгөөр буурч 11.7 их наяд төгрөгт хүрчээ. Үүнээс татан буугдсан¹ банкуудын зээлийг хасч тооцвол нийт үлдэгдэл 11.5 их наяд төгрөг байгаа нь өмнөх улирлаас 1.1 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 3.7 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин банкуудаас МИК-д шилжүүлсэн² зээлийн багцыг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 3.4 хувийн өсөлттэй байна.

Зураг 1. Зээлийн үлдэгдэл




¹ Зоос, Хадгаламж банк.

² МИК-д шилжүүлсэн зээл 2.1 их наяд төгрөг байгаа ба уг дүн нь банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагддаг.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл хэрэглээний, цалингийн болон тэтгэврийн зээл нийт зээлийн үлдэгдлийн 28.0 хувь, худалдааны салбар 14.0 хувь, барилгын салбар 13.0 хувь, орон сууцны ипотекийн зээл³ 12.7 хувь, боловсруулах үйлдвэрлэл 10.9 хувь, уул уурхайн салбар 10.1 хувь, бусад салбарууд 11.3 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 2. Зээлийн үлдэгдэл /гол салбараар/

/тэрбум ₮/



Зураг 3. Зээлийн үлдэгдэл /төгрөг, валютаар/




Салбаруудын зээлийн үлдэгдлийг төгрөг ба валютын эзлэх хувиар нь авч үзвэл хөдөө аж ахуйн зээл, хэрэглээний зээл, орон сууцны ипотекийн зээл төгрөгөөр түлхүү олгогдож байгаа бол уул уурхай, мэдээлэл холбоо, санхүү даатгал болон боловсролын салбаруудад валютын зээл давамгайлж байна.

Зээлийн жилийн өөрчлөлт сүүлийн 4 улирлын турш сөрөг үзүүлэлттэй байсан бөгөөд тайлант улиралд өнгөрсөн оны мөн үеэс 11.5 нэгж хувиар буурч -3.7 хувьд (МИК-д шилжүүлсэн багцыг хассанаар) хүрсэн байна. Харин 2016 он гарсаар уул уурхай, барилгын салбарын болон хэрэглээний зээл нэмэгдсэн нь нийт зээлийн жилийн өөрчлөлтөд эерэгээр нөлөөлсөн бөгөөд тайлант улирлын байдлаар нийт зээл өмнөх улирлаас 2.8 нэгж хувиар өссөн байна. Бусад гол салбарууд болох барилга, худалдаа, боловсруулах үйлдвэрлэлийн зээл олголт тогтвортой байна.


³ МИК-д шилжүүлсэн ОСИЗ-ийг хассанаар

Зураг 4. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/




Тайлант улиралд банкууд нийт 2290.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Шинээр олгосон зээл өмнөх улирлаас 2.3 хувь буюу 50.7 тэрбум төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үеэс 5.6 хувь буюу 121.8 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Шинээр олгосон зээлийг салбаруудаар авч үзвэл 1101.9 тэрбум төгрөг буюу 48.1 хувийг хэрэглээний зээлд, 384.3 тэрбум төгрөг буюу 16.8 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 229.6 тэрбум төгрөг буюу 10.0 хувийг барилгын салбарт, 150.9 тэрбум төгрөг буюу 6.6 хувийг орон сууцны ипотекийн зээлд, 134.2 тэрбум төгрөг буюу 5.9 хувийг боловсруулах салбарт, 39.9 тэрбум төгрөг буюу 1.7 хувийг уул уурхайн салбарт тус тус олгожээ.

Зураг 5. Олгосон ба төлөгдсөн зээл




Зураг 6. Олгосон зээл /салбараар/



Тайлант улиралд олгосон зээлийн 43.1 хувийг 1 жил хүртэлх хугацаатай, 45.6 хувийг 1-5 жилийн хугацаатай, 11.2 хувийг 5 жилээс дээш хугацаатай олгосон бөгөөд, 1 жил хүртэл хугацаатай зээлийн хувийн жин өмнөх оны мөн үеэс 9.5 нэгж хувиар, 1-5 хүртэл жилийн хугацаатай зээл 0.6 нэгж хувиар тус тус нэмэгдсэн бол 5-аас дээш жилийн хугацаатай зээлийн хувийн жин 2.7 нэгж хувиар буурсан байна.


Зураг 7. Олгосон зээл /хугацааны ангиллаар/




Тайлант улиралд 2220.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн нь өмнөх улирлаас 2.5 хувь буюу 56.1 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 0.9 хувь буюу 20.7 тэрбум төгрөгөөр тус тус багассан байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 83.6 хувь нь хугацаандаа байгаа зээл, 8.2 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 8.2 хувь нь чанаргүй зээл байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 405.4 тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 105.1 тэрбум төгрөгөөр өсч 962.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 262.2 тэрбум төгрөг буюу 37.4 хувиар, өмнөх улирлаас 141.2 тэрбум төгрөг буюу 17.2 хувиар өсч 963.6 тэрбум төгрөгт хүрчээ. Харин татан буугдсан Зоос, Хадгаламж банкуудын чанаргүй зээлийг хасч тооцвол нийт зээлд эзлэх чанаргүй зээл 6.3 хувь байна.

Зураг 8. Чанаргүй зээлийн хэмжээ ба өөрчлөлт



Зураг 9. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл /тухайн салбартаа эзлэх хувиар/




Гол салбарууд дахь чанаргүй зээлийн хувь хэмжээг авч үзвэл уул уурхайн олборлолтын салбарт 24.9 хувь, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 12.6 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 10.6 хувь, хөдөө аж ахуйн салбарт 9.2 хувь, барилгын салбарт 5.3 хувь байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийн хувьд уул уурхайн салбарт 26.3 хувь, барилгын салбарт 13.8 хувь, хөдөө аж ахуйн салбарт 12.4 хувьтай байна.


Нийт банкны салбарын чанаргүй зээлийн 30.6 хувийг уул уурхайн салбар, 21.4 хувийг худалдааны салбар, 14.2 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 8.3 хувийг барилгын салбар, 25.5 хувийг бусад салбаруудын чанаргүй зээл бүрдүүлж байна.

Хувийн хэвшил, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл банкны салбарын зээлийн 97.8 хувийг бүрдүүлжээ. Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 22.3 хувийг барилгын салбарт, 19.5 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 18.3 хувийг боловсруулах үйлдвэрийн салбарт, 16.0 хувийг уул уурхайн салбарт, 23.9 хувийг бусад салбарт тус тус олгожээ.

Зураг 10. Хувийн байгууллагын зээл



Зураг 11. Иргэдийн зээл



Иргэдийн зээлийн үлдэгдлийн 49.7 хувийг орон сууцны ипотекийн зээл (МИК-д шилжүүлсэн зээлийг оруулснаар) бүрдүүлж байгаа бол 40.5 хувийг цалингийн зээл, хадгаламж барьцаалсан зээл, картан зээл, тэтгэврийн зээл болон бусад хэрэгцээнд зориулсан зээл, 5.3 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 4.5 хувийг бусад салбарт тус тус олгосон байна.

Иргэд, хувийн байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлт тайлант улиралд буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, хувийн байгууллагын зээл 2.1 хувиар буурсан нь өмнөх оны мөн үеэс 8.5 нэгж хувиар, иргэдийн зээл 7.9 хувиар буурсан нь өмнөх оны мөн үеэс 16.8 нэгж хувиар тус тус багассан үзүүлэлт юм. Харин өмнөх улирлын зээлийн үлдэгдэлтэй харьцуулахад хувийн байгууллагын зээл 1.1 нэгж хувь, иргэдийн зээл 4.2 нэгж хувиар тус тус нэмэгдсэн байна. МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг оруулж тооцвол иргэдийн зээл өмнөх оноос 7.1 хувиар өссөн байна.


Зураг 13. Нэгж зээлийн хэмжээ /салбараар/



Тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг салбараар авч үзвэл хэрэглээний зээл (20.0%), хөдөө аж ахуй (19.5%), тээвэр агуулах (18.1%) зэрэг салбарууд өндөр хувьтай байгаа бол худалдаа (15.7%), барилга (15.4%), боловсруулах (14.2%) салбаруудад олгосон зээлийн хүү харьцангуй бага байна.


Банкуудын тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа⁴ 32.7 сар байна.

Зураг 12. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн жилийн өсөлт



Тухайн салбарт олгосон зээлийн үлдэгдлийг нийт зээлдэгчдийн тоонд харьцуулахад уул уурхай салбар хамгийн өндөр (4 тэрбум 572 сая ₮) дүнтэй байсан бол мэдээлэл холбоо (546.3 сая ₮), барилгын салбар (538.2 сая ₮) удаалж байна. Харин худалдаа, хөдөө аж ахуй, орон сууцны ипотекийн зээлийн нэгж зээлийн хэмжээ 46-62 сая төгрөгийн хооронд байгаа бол хэрэглээний зээлийн нэг зээлдэгчид ноогдох хэмжээ хамгийн бага дүнтэй буюу 3.8 сая төгрөг байна.

Зураг 14. Олгосон зээлийн хүү /салбараар/




⁴ Тайлант улиралд олгосон ОСИЗ-ийн жигнэсэн дундаж хугацааг хассанаар

Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээл


Тайлант улиралд иргэдийн зээл 5046.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 27.8 хувь буюу 1405.3 тэрбум төгрөг нь ипотекийн, 28.5 хувь буюу 1436.6 тэрбум төгрөг нь цалингийн, 15.0 хувь буюу 756.2 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, 10.4 хувь буюу 522.9 тэрбум төгрөг нь тэтгэврийн, 6.0 хувь буюу 301.0 тэрбум төгрөг нь хэрэглээний, 12.4 хувь буюу 624.9 тэрбум төгрөг нь бусад зээл байна.

Иргэдийн нийт зээлд эзлэх чанаргүй зээл 2.9 хувь байгаагаас хэрэглээний зээл 3.0 хувь, цалингийн зээл 2.0 хувь, ипотекийн зээл 1.7 хувьтай байна. Тэтгэврийн зээлийн эргэн төлөлт харьцангуй сайн байна.

Зураг 15. Иргэдийн зээл /зориулалтаар/



Зураг 16. Чанаргүй зээлийн хувь /зориулалтаар/



Иргэдэд олгосон зээлийн дундаж хүү 19.3 хувь байгаа бөгөөд хэрэглээний (21.1%) болон цалингийн (20.5%) зээлийн хүү нийт дундажаас илүү өндөр байна. Харин иргэдэд олгогдсон зээлийн дундаж хугацааны хувьд орон сууцны ипотекийн зээл 187.6 сар (16.8 жил) цалингийн зээл харьцангуй урт буюу 33.2 сар⁵ (2.8 жил) байгаа бол тэтгэврийн зээл хамгийн богино (10.1 сар) байна.

	Зээлийн дундаж хүү /хувь/	Зээлийн дундаж хугацаа /сар/
Иргэдийн зээл	19.3%	39.0
Ипотекийн зээл	9.1%	187.6 (16.8 жил)
Хэрэглээний зээл	21.1%	16.0
Цалингийн зээл	20.5%	33.2 (2.8 жил)
Тэтгэврийн	18.0%	10.1
Бусад зээл	21.4%	11.0


Тайлант улиралд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд нийт 267.3 тэрбум төгрөгийн зээл олгож, тайлант улирлын эцэст нийт 47860 иргэд, 5391 аж ахуйн нэгжүүд 2021.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 37.4 хувь буюу

5 Зарим банкуудаас 2016 оны I улиралд хэрэгжүүлсэн “Хэрэглээний зээлийн аян”-ы хүрээнд олгосон зээлээс хамаарч цалингийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа уртсав.


756.2 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэдийн зээл, 62.6 хувь буюу 1265.3 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн зээл байна.

ЖДҮ-ийн зээлийг салбараар авч үзвэл худалдаа (33.1%) болон боловсруулах үйлдвэрлэлийн (23.5%) салбарт түлхүү олгогдсон байна.

Зураг 17. ЖДҮ-ийн зээлийн хэмжээ /салбараар/



Зураг 18. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



ЖДҮ-ийн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 8.5 хувь байгаа бөгөөд үйлчилгээ, барилга, боловсруулах салбарын ЖДҮ эрхлэгч иргэдэд олгосон зээлийн чанаргүй зээлийн хувь харьцангуй өндөр байгаа бол худалдаа, барилгын салбарынх харьцангуй бага байна. ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн дундаж хүү болон хугацааг харьцуулахад иргэдэд олгогдож буй зээлийн хүү харьцангуй өндөр, хугацаа урт байгаа бол ААН-ийн зээлийн хүү бага, харин дундаж хугацаа нь богино байна.

Зураг 19. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа

